




Jarvis LMS

Хэрэглэгчийн гарын авлага

Хувилбар (1.3.1)


УЛААНБААТАР 2026



- **Android:**
Play Store- руу орно.
Хайлт хийх хэсэгт **JARVIS LMS** нэрийг бичнэ.
Суулгах (**Install**) товчийг дарж суулгана.
- **IOS:**
App store- руу орно.
Хайлт хийх хэсэгт **JARVIS LMS** нэрийг бичнэ.
Суулгах (**Install**) товчийг дарж суулгана.


2. Нэвтрэх холбоос оруулах.

1. **Нэвтрэх холбоос** хэсэгт байгууллагын домэйн хаягаа оруулна.
2. Домэйн хаягаа дараах хоёр аргаар оруулах боломжтой:
 - **Гараар бичих:**
 - <https://> гэж бичсэний дараа өөрийн байгууллагын домэйн хаягийг залгаж бичнэ.
 - **QR код уншуулах:**
 - Өөрийн байгууллагын веб рүү хандан нэвтрэх товчны дор байрлах QR дээр даран байгууллагын QR кодыг апп-р уншуулна.
 - Зургийн сангаас QR code сонгон оруулах боломжтой



Анхаарах:

- Домэйн хаяг буруу бичсэн тохиолдолд нэвтрэх боломжгүй.
- Байгууллага бүрийн домэйн хаяг өөр өөр байдаг тул заавал өөрийн байгууллагын QR-г ашиглана уу.




3. Системд нэвтрэх

- **Нэвтрэх нэр оруулах:**
Нэвтрэх нэр талбарт өөрийн хэрэглэгчийн нэрийг оруулна.
- **Нууц үг оруулах:**
Нууц үг талбарт та нууц үгээ оруулна.
- **Нэвтрэх товч дарна:**
Бүх мэдээллээ шалгаад **нэвтрэх** товчийг дарна.


4. Нууц үг сэргээх

1. Нууц үгээ мартсан бол **нууц үг сэргээх** товч дээр дарна.
2. Нэвтрэх нэр хэсэгт өөрийн **нэвтрэх нэрийг** оруулна.
3. Системд бүртгэлтэй таны мэйл хаяг руу нэг удаагийн код илгээгдэнэ. Мэйл хаягт ирсэн нэг удаагийн код оруулах талбарт оруулснаар шинэ нууц үг оруулах хуудас руу шилжинэ.
4. Шинэ **нууц үг** үүсгэн давтан оруулна.





5. Цахим сургалтын карт, цахим сургалттай танилцах



5.1 Цахим сургалтын карт

Сургалтын карт дээр сургалтын нэр, удирдагч багшийн нэр, үүсгэсэн огноо, бүлгийн тоо, сонгон судлах хичээл бол таних тэмдэг, хугацаатай бол үлдсэн хоногийн тоо мөн үзсэн хувийг харуулна.


а) **Шинэ сургалт:** нь шинэ гэсэн тагтай харагдах ба ямар нэг прогресс хадгалагдаагүй байна.

б) **Хугацаатай сургалт:** бол үлдсэн хоногийн тоог харуулна.

в) **Сонгон судлах сургалт:** Өөрийн хүсэлтээр сонгон элссэн сургалтууд.

г) **Хугацаа дууссан сургалт:** Хугацаатай сургалтын хугацаа дууссан бол саарал өнгөтэй болж үзэх боломжгүй байна.

5.2 Цахим сургалтын таб



а) **Агуулга:** Агуулга таб нь тухайн сургалтын нийт бүлэг, бүлэг доторх сургалтын тоо, үзсэн сургалтын хувийг харуулна.

б) **Танилцуулга таб:** Сургалтын товч танилцуулга, сургалтын ангилал, сургалтын төрөл, багц цагийн мэдээллийг харуулна.


*Дараах 4 таб нь цахим сургалтанд тохируулсан бол харагдана.

с) **Хавсралт таб:** Сургалтад нэмэлт хавсралт файл хавсаргасан бол хавсралт табд харагдана. Файл дээр дарахад шууд татагдана. Утасны file дотор хадгалагдана.

д) **Тест:** Сургалттай бүрэн танилцсаны дараа тест таб дээр дарахад тестийн босго оноо, оролдлогын тооны мэдээллийг харуулах ба эхлүүлэх товч идэвхитэй болсон байна. Тест бөглөсний дараа авсан онооны мэдээллийг мөн харуулна.

е) **Үнэлгээний хуудас:** Үнэлгээний хуудсыг нэг удаа бөглөх ба эхний удаа ороход нэг удаа бөглөх анхааруулах мессеж харуулж бөглөх товч идэвхтэй байна. Үнэлгээг бөглөсний дараа дахин ороход Үнэлгээг бөглөсөн байна текст харуулж бөглөх товч харагдахгүй болсон байна.



ф) **Сертификат:** Тестгүй сургалттай бүрэн танилцсан бол сертификатыг шууд авах боломжтой. Тесттэй сургалтын сертификат авах бол тестийн босго оноонд хүрсэн шалгуурыг давснаар сертификат олгогдоно. Хэрэв амжилттай сертификат авсан бол сертификат таб дээр харуулна. Мөн татаж авах боломжтой байна.



5.3 Цахим сургалттай танилцах


а) Видео сургалттай танилцах

- Сургалт руу ороход автоматаар тоглож эхэлнэ. Сургалт гүйлгэх боломжтой бол урагш, хойш гүйлгэх товч, тоглуулах, зогсоох товчууд харагдана. Гүйлгэх боломжгүй сургалт дээр зөвхөн тоглуулах, зогсоох товч харагдана.
- Бүтэн дэлгэцээр тоглуулахад өмнөх, дараах хичээл рүү шилжих товчууд нэмэгдэж харагдана.




б) PDF сургалттай танилцах

- Тоглуулагч дээр хуудасны дугаар, бүтэн дэлгэцээр тоглуулах товч, буцах товчууд харагдана.
- Гүйлгэх боломжтой сургалтыг хуудас сонгож үзэх боломжтой.
- Гүйлгэх боломжгүй сургалтыг нэг нэг хуудсаар гүйлгэж үзнэ.
- Бүтэн дэлгэцээр мөн тоглуулах боломжтой байна.





6. Хайлт, шүүлт



- Хайлтын талбар дээр дарахад dropdown-р сүүлд бичиж хайсан утгуудыг харуулана. Хайлт хийгээгүй бол хоосон байна.

- Сүүлд хайсан утгаас хамгийн сүүлийн **25** утгыг урдаа томруулдаг шилний icon-той харуулна.


- Хайлт цэвэрлэх товч баруун талд байрлана.

- Утгаа оруулан хайх дарах үед сургалт, шалгалтаар ялган харна


- Бүгд дарах үед сонгосон цэсний бүх илэрц рүү шилжинэ.

Шүүлт

- Сургалт, шалгалт вебинарын ангиллын жагсаалт харагдана.
- Хэрэглэгч шүүж харах ангиллаа сонгоод “**Шүүх**” товчийг дарснаар зөвхөн сонгосон ангиллын сургалтууд харагдана.




- “Цэвэрлэх” товчийг дарснаар сонгосон ангиллын шүүлт цэвэрлэгдэж, бүх сургалт шалгалт вебинар дахин харагдана.




- Утга бичих үед удирдагч багш, сургалтаас, шалгалт, вебинараас тус бүр 3 илэрц харуулна.

7. Профайл



- **Хэрэглэгчийн профайл:** Хэрэглэгчийн овог нэр, хэрэглэгчийн эрх, хэрэглэгчийн группийн мэдээллүүд харагдана.
- **Мэдэгдэл:** Хэрэглэгчид шинэ сургалт оноогдож нийтлэгдсэн бол мэдэгдэлийн тоо нэмэгдэнэ. Мэдэгдэл цэсрүү орж шинэ сургалтын мэдэгдлээс сургалт руу дамжин орох боломжтой.
- **Гарах:** Гарах товч дарвал системээс гарахдаа итгэлтэй байна уу? Диалог харуулж тийм дарвал системээс гарна. Буцах дарвал диалог хаагдана.

8. Шалгалт



- **Идэвхтэй:** Эхэлсэн төлөвтэй шууд явагдаж байгаа шалгалтын жагсаалт

- Шалгалт явагдаж байна гэсэн улаан хүрээтэй чип харагдана. Тодорхой хугацаанд явагдана. Жишээ нь: 14:00-14:30. Шууд явагдах шалгалт нь нэг удаагийн оролдлоготой байна.



- **Идэвхтэй:** Эхэлсэн төлөвтэй шалгалтын жагсаалт

- Албан ёсны шалгалт
 - Хугацаа болон оролдогийн тоо заасан шалгалтууд байх болно.

- Өөрийгөө бэлтгэх шалгалт


- Хэрэглэгч шалгалтанд бэлдэх зориулалттай оролдогийн тоо хязгааргүй байна.

- **Идэвхтэй:** Удахгүй эхлэх төлөвтэй шалгалтын жагсаалт
 - 24 цаг дотор эхлэх бол шар хүрээтэй харагдана.
 - 24 цагаас илүү бол саарал хүрээтэй харагдана.




Дууссан төлөвтэй шалгалт

- Шууд өгсөн шалгалт нь картнаасаа дэлгэрэнгүй болон хариу харах товчтой байна
- Тодорхой хугацаанд авах шалгалт нь дэлгэрэнгүй лүү ороод хариу харах товч байна.




Хариу харах товч \хариу харахгүй шалгалт мөн байж болно.\

- Буруу хариулт нь улаан, зөв хариулт нь ногоон өнгөөр ялгарч харагдана.




Хойшлогдсон төлөвтэй шалгалт

- Хойшлогдсон шалтгаан нь улаан хүрээнд харагдана.




Шалгалт өгөх үе




Шалгалтын дэлгэрэнгүй

- Шалгалтын дэлгэрэнгүйгээс босго оноо, сертификаттай эсэх, шалгалтын хугацаа зэрэг хэрэгтэй мэдээллээ аван Эхлүүлэх товч дараад шалгалт руугаа орно.




Сертификаттай шалгалт

- Сертификаттай шалгалтанд босго оноогоо давсанаар сертификат авна.



Сертификаттай шалгалт

- Сертификаттай шалгалтанд босго оноогоо давахгүй бол сертификат авахгүй.





Шалгалтын хугацаа дуусах

- Шалгалтын хугацаа дуусаад хариу харах боломжтой
- Дүнгээ харна

Хариу харах товч

- Буруу хариулт нь улаан, зөв хариулт нь ногоон өнгөөр ялгарч харагдана.



Дүн харах товч

- Олон оролдлоготой шалгалт өгөөд өөр өөр дүн авсан бол тухайн шалгалтыг хамгийн өндөр оноогоор тооцно
- Мөн сүүлд өгсөн шалгалтын оноог харуулна.

Шалгалтын асуултын төрөл

9:30 1/10

1. Галын аюул үүссэн үед авах зөв арга хэмжээнүүдийг сонгоно уу.
/Олон сонголттой асуулт/

☒ Галын дохио дуугармагц ойр орчимд байгаа хүмүүст анхааруулах

☒ Эвакуацийн гарцаар тайван гарч явах

☐ Ажлаа дуусгаж байгаад дараа нь гарах

☒ Гал унтраагч ашиглах боломжтой бол эхний оролдлого хийх

2. Ажлын байранд ослоос урьдчилан сэргийлэх хамгийн эхний алхам юу вэ?

Хамгаалах хэрэгсэл зүүх

00:30

Дуусгах

- Олон сонголттой асуулт
 - Хариултуудаас олныг сонгох боломжтой
- *Бүх хариултыг сонговол 0 оноо өгнө.
- <https://erinsystemslc.atlassian.net/browse/LMS-6473>

9:30 2/10

2. Ажлын байранд ослоос урьдчилан сэргийлэх хамгийн эхний алхам юу вэ?

Хамгаалах хэрэгсэл зүүх

Ажлын байрны эрсдэлийг таних

Ажлаа хурдан дуусгах

Дүрмийг бусдаас асуух

3. Аюулгүй ажиллагааны зааврыг ажилтан бүр дагаж мөрдөхгүй бол ямар эрсдэлүүд үүсэж болохыг тодорхой жишээтэй тайлбарлана уу.

Зөв хариултыг бичинэ үү.

4. Галын гарцыг бараагаар хаах нь зөвхөн түр хугацааны бол асуудалгүй.

Тийм

00:30

Дуусгах

- Нэг сонголттой асуулт
 - Хариултуудаас нэгийг сонгох боломжтой

9:30 3/10

3. Аюулгүй ажиллагааны зааврыг ажилтан бүр дагаж мөрдөхгүй бол ямар эрсдэлүүд үүсэж болохыг тодорхой жишээтэй тайлбарлана уу.

Зөв хариултыг бичинэ үү.

4. Галын гарцыг бараагаар хаах нь зөвхөн түр хугацааны бол асуудалгүй.

Тийм

Үгүй

5. Дараах үгстэй зөв утгатайг нь сонгоно уу. /Харгалзуулах асуулт/


1. Ашиглалтад оруулахыг хориглоно, аюул үүсгэх эрсдэлтэй

Зөв хариултыг сонгоно уу.

00:30

Дуусгах

- Нээлттэй асуулт
 - Тухайн асуултанд хариулж бичнэ




сонголттой асуулт


- Асуултанд тийм эсвэл үгүй гэж хариулна

- Тийм үгүй

- Харгалзуулах асуулт
 - Тодорхойлолтыг зөв хариутай харгалзуулна.




9. Вебинар




Идэвхтэй: Эхэлсэн болон удахгүй эхлэх вебинарын жагсаалт харагдана.

- Эхэлсэн вебинар
- Шууд явж байгаа вебинарын жагсаалт харагдана
- Удахгүй эхлэх вебинар
- Нийтэлсэн байгаа удахгүй эхлэх вебинарын жагсаалт харагдана.


Дууссан: Дууссан вебинарын жагсаалт харагдана. Оролцсон вебинарууд “Оролцсон” чиптэй байна.






Удахгүй эхлэх вебинар: Удахгүй эхлэх вебинарын дэлгэрэнгүй мэдээлэл дараах байдлаар харагдана.



Эхэлсэн: Шууд явж байгаа вебинарын дэлгэрэнгүй мэдээлэл харагдана. Элсэх товч идэвхтэй байна.





Ангиллаар шүүх: Вебинарыг ангиллаар шүүнэ. Аль нэг ангилал сонгоод шүүх товчон дээр дарна.

Элсэх дараад камер болон дуугаа нээж хаах сонголтоо хийгээд уулзалтандаа орно.



Вебинарт ороод тохиргоо цэсээс дараах мэдээлэл болон тохиргоонууд байна.

Зурвас илгээх хэсэг

